



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/31-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 70584207 Цахим хаяг: Ukhaanbilegm@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	123
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	134
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	145
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	166
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	177





2.1. Оршил

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Наранжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 11-нээс 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 8 дугаар сургууль нь “1-12 дугаар ангийн 1548 сурагчдад ерөнхий боловсролын суурь, бүрэн дунд боловсролыг чанартай эзэмшүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 8 дугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoluos программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,427,673.1 мянган төгрөгөөс тооцон 28,553.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 34,352.4 мянган төгрөгөөр өсгөсөн нь тайлант онд санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 352,133.3 мянган төгрөгөөр өссөн байна. Материаллаг хэмжээний өөрчлөлт орсон бараа материалын болон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	292,912.8	330,102.4	37,189.5
Үндсэн хөрөнгө	4,551,226.2	5,049,492.6	498,266.4
Элэгдэл	-315,791.9	-499,111.0	-183,319.0
Нийт хөрөнгө	4,528,350.6	4,880,484.0	352,133.3
Өр төлбөр	0.0	126.9	126.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,528,350.6	4,880,357.0	352,006.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,528,350.6	4,880,484.0	352,133.3

Бараа материалын дансны үлдэгдэл өмнө оноос өссөн нь БСШУСЯ-наас үнэ төлбөргүй ирүүлсэн сурах бичгийн дүнгээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. БСШУСЯ-наас 430,492.1 мянган төгрөгийн барилгын их засвар, аймгийн ЗДТГ-аас 75,606.1 мянган төгрөгийн хичээлийн А, Б байрыг холбосон явган хүний зам, Хэрлэн сумын ЗДТГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 4,400.0 мянган төгрөгийн хүлэмж, гүнзгий ангийн төлбөрөөс 12,420.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн дүнгээр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл нь цалингаас суутгасан татварын тооцооллыг алдаатай хийсэн дүнг аудитын явцад тусгуулсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо өссөн нь хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нэмэлт орлого	0	21,005.0	-21,005.0	100
Нийт дүн	0	21,005.0	-21,005.0	100

Хэрлэн сумын 8 дугаар сургууль нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 1,509,569.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,442,726.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 66,843.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,545,677.2 мянган төгрөг буюу 102,4 хувьтай байна. Энэ нь төлөвлөгөөнөөс БСШУСЯ-наас ирүүлсэн багш судлаач төсөл болон өөрийн үндсэн үйл ажиллагаанаас бий болсон орлогын нийт 36,107.4 мянган төгрөгөөр илүү байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагч БСШУСЯ-наас багш судлаач төсөлд 15,102.4 мянган төгрөгийн санхүүжилт болон өөрийн орлогын 21005,0 мянган төгрөгөөр /заалны түрээс 1,398.5 мянга, гүнзгий ангийн төлбөр 18,916.0 мянган, тендерийн баримт бичиг 247.5 мянган, Халхголын ойн төслийн тэмцээний шагнал 243.0 мянган төгрөг/ нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээс төслийн үйл ажиллагааны хүрээнд багшийн цалинд 8,425.1 мянган төгрөг, нийгмийн даатгалд 1,053.1 мянган төгрөг, бичиг хэрэгт 247,5 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлс 13,740.9 мянган төгрөг, урсгал засварт 2,751.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 9,88.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 165,345.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 115,113.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 49,896.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 335.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 49,896.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага тогтоолоо. Үүнд:

1. Шатахууны зардлаас 294,1 мянган төгрөгийн хангамжийн материал нөөцөлсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй, татварын ебаримт программд 40,943.9 мянган төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Сургуулийн хүүхдийн хоолны мах нийлүүлэгчтэй гэрээ байгуулахдаа “зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөх тохиолдолд захиалагчид урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцооноор махыг нийлүүлнэ” гэж тусгаснаар нийт 1,415.2 мянган төгрөгийг илүү төлсөн зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.4-т “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараах тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж

болно.” үүнд 40.4.1-т “хоёр жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөн;”, 40.4.2-т “суурь үнэ огцом өөрчлөгдсөн., 41.1.2-т “энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх.”-ийг хориглох тухай заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Сургуулийн хүүхдийн хоолны материалын тендерийн багцад байхгүй хүнс авсан, багцын дүнгээс хэтэрсэн худалдан авалт хийсэн 7,243.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.2-т “«Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно.”, 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 335,5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 8 дугаар сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн ебаримтад бүртгүүлж ажиллах зөвлөмжийн биелэлт 77,0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Албан томилолтыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж ажилласан. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ хөтлөлтийн дансны заавартай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Бүртгэл бүрэн үнэн, зөв хөтлөгдөхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны заавар мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд худалдаж авсан эм бэлдмэлийг зарцуулалгүй нөөцлөн авч үлдсэн байна. Энэ нь “Эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай” хуулийн 23.3-т “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эмнэлгийн яаралтай тусламж болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах зориулалтын нөөцийн агуулахтай байна.” гэсэн заалтад нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Эм, бэлдмэлийн чанар муудах.



2.3. Өгсөн зөвлөмж:

Эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн бүтээгдэхүүний тухай хуулийн 23.2.1-т заасныг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>292,916,434.73</u>	<u>330,102,449.60</u>
33	АВЛАГА	3,580.27	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,580.27	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	292,912,854.46	330,102,449.60
351	Түүхий эд материал	67,797,963.70	97,323,270.84
35110	Тусгай зориулалттай материал	67,260,492.70	96,540,799.84
35130	Эм боох материал	537,471.00	782,471.00
354	Хангамжийн материал	225,114,890.76	232,779,178.76
35410	Бичиг хэргийн материал	2,553,102.00	60,000.00
35420	Аж ахуйн материал	12,120.00	120,000.00
35470	Бусад хангамжийн материал	222,549,668.76	232,599,178.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,235,434,262.60</u>	<u>4,550,381,596.23</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	00.00	00.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,235,434,262.60	4,550,381,596.23
392	Биет хөрөнгө	3,787,577,287.69	4,103,043,521.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,649,490,362.44	4,079,982,518.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-63,867.96	-149,096,968.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	294,154,622.62	282,072,695.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-220,123,752.57	-239,433,901.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,497,831.79	145,347,831.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	-87,572,063.35	-101,224,039.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,170,673.00	85,176,854.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,836.28	-819,786.96
39217	Ном	1,038,318.00	1,038,318.00
393	Биет бус хөрөнгө	447,856,974.91	447,338,074.87
39301	Програм хангамж	9,499,420.00	9,499,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,017,445.09	-8,536,345.13
39303	Бусад биет бус хөрөнгө	446,375,000.00	446,375,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,528,350,697.33</u>	<u>4,880,484,045.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>126,972.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	126,972.00
413	Өглөг	00.00	126,972.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	126,972.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,528,350,697.33</u>	<u>4,880,357,073.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,528,350,697.33	4,880,357,073.83

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,441,984,414.04	1,441,984,414.04
51101	Өмч: - төрийн	1,441,984,414.04	1,441,984,414.04
512	Хуримтлагдсан үр дүн	906,600,266.91	1,262,470,883.65
51210	Өмнөх үеийн үр дүн	906,600,266.91	910,464,507.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	352,006,376.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,179,766,016.38	2,175,901,776.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,528,350,697.33	4,880,484,045.83

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,388,747,288.03	2,084,550,664.14
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,492,480.03	538,873,444.14
120	Нийтлэг татварын бус орлого	49,492,480.03	458,867,263.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,492,480.03	458,867,263.14
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,492,480.03	458,867,263.14
121	Хөрөнгийн орлого	00.00	80,006,181.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	00.00	80,006,181.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,679,708.00	102,951,120.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,306,575,100.00	1,442,726,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,679,708.00	36,107,420.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,255,708.00	15,102,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,424,000.00	21,005,020.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	66,843,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	66,843,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,427,673,115.58	1,732,544,287.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,427,673,115.58	1,732,544,287.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,326,802,762.66	1,656,162,500.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	984,487,247.25	1,198,159,764.40
210101	Үндсэн цалин	762,133,127.25	884,556,964.40
210102	Нэмэгдэл	120,900,000.00	185,867,600.00
210104	Урамшуулал	101,454,120.00	127,735,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,020,453.35	149,397,617.63
210201	Тэтгэврийн даатгал	76,939,580.08	103,190,234.32
210202	Тэтгэмжийн даатгал	7,813,971.85	10,029,125.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,767,465.19	11,341,931.51



Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	1,863,585.13	2,257,893.29
210205	Эрүүл мэндийн даатгал	18,635,851.10	22,578,433.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,226,854.00	59,021,305.00
210301	Гэрэл, цахилгаан	12,546,577.00	14,957,882.00
210302	Түлш, халаалт	36,268,124.00	34,211,940.00
210303	Цэвэр, бохир ус	10,412,153.00	9,851,483.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,530,303.78	16,359,628.00
210401	Бичиг хэрэг	3,973,351.00	8,625,152.00
210402	Тээвэр, шатахуун	3,465,696.00	390,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,595,056.00	5,012,426.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	572,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,496,200.78	1,759,500.00
2105	Нормативт зардал	641,579.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	641,579.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,426,076.24	9,181,192.00
210604	Урсгал засвар	18,426,076.24	9,181,192.00
2107	Томилолт, зочны зардал	354,900.00	810,500.00
210702	Дотоод албан томилолт	354,900.00	810,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,025,000.00	640,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,025,000.00	640,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,090,349.04	222,591,593.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	635,000.00	2,910,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,177,772.76	11,709,690.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,277,576.28	207,971,903.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,870,352.92	76,381,787.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,452,586.60	73,190,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,555,810.60	73,190,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,896,776.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	417,766.32	3,190,887.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	417,766.32	3,190,887.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-38,925,827.55</u>	<u>352,006,376.50</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	791,272,507.66	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	791,272,507.66	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-791,272,507.66	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-830,198,335.21</u>	<u>352,006,376.50</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------



	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,339,254,808.00	1,545,677,220.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,339,254,808.00	1,545,677,220.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,306,575,100.00	1,442,726,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,679,708.00	36,107,420.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,255,708.00	15,102,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,424,000.00	21,005,020.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	66,843,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	66,843,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,339,254,808.00	1,545,677,220.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,339,254,808.00	1,545,677,220.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,238,384,455.08	1,469,295,432.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	983,857,990.00	1,198,029,212.13
210101	Үндсэн цалин	761,537,891.00	884,426,412.13
210102	Нэмэгдэл	120,900,000.00	185,867,600.00
210104	Урамшуулал	101,420,099.00	127,735,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,857,216.08	149,397,617.63
210201	Тэтгэврийн даатгал	79,995,615.33	103,190,234.32
210202	Тэтгэмжийн даатгал	8,181,486.23	10,029,125.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,201,757.77	11,341,931.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,857,595.79	2,257,893.29
210205	Эрүүл мэндийн даатгал	18,620,760.96	22,578,433.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,226,854.00	59,021,305.00
210301	Гэрэл, цахилгаан	12,546,577.00	14,957,882.00
210302	Түлш, халаалт	36,268,124.00	34,211,940.00
210303	Цэвэр, бохир ус	10,412,153.00	9,851,483.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,814,200.00	27,957,556.00
210401	Бичиг хэрэг	1,551,948.00	1,568,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,995,696.00	684,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,595,056.00	5,012,426.00
210404	Ном, хэвлэл	968,300.00	882,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	591,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,703,200.00	19,217,280.00
2105	Нормативт зардал	5,090,250.00	2,215,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	598,000.00	125,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,492,250.00	2,090,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,611,200.00	7,751,822.00
210604	Урсгал засвар	16,611,200.00	7,751,822.00
2107	Томилолт, зочны зардал	354,900.00	810,500.00



210702	Дотоод албан томилолт	354,900.00	810,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	983,000.00	787,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	983,000.00	787,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,588,845.00	23,324,520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	4,150,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,788,845.00	19,174,520.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,870,352.92	76,381,787.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,452,586.60	73,190,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,555,810.60	73,190,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29,896,776.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	417,766.32	3,190,887.24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	417,766.32	3,190,887.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,441,984,414.04	2,179,766,016.38	906,600,266.91	4,528,350,697.33



Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,864,240.24	3,864,240.24
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,441,984,414.04	2,179,766,016.38	910,464,507.15	4,532,214,937.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-3,864,240.24	00.00	-3,864,240.24
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	352,006,376.50	352,006,376.50
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,441,984,414.04	2,175,901,776.14	1,262,470,883.65	4,880,357,073.83

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,509,569,800.00	1,509,569,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,569,800.00	1,509,569,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,436,378,900.00	1,433,188,012.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,189,612,900.00	1,189,604,076.13
210101	Үндсэн цалин	876,010,100.00	876,001,276.13
210102	Нэмэгдэл	185,867,600.00	185,867,600.00
210104	Урамшуулал	127,735,200.00	127,735,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,701,800.00	148,344,475.63
210201	Тэтгэврийн даатгал	101,117,300.00	102,137,092.32
210202	Тэтгэмжийн даатгал	11,896,300.00	10,029,125.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,516,800.00	11,341,931.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,379,200.00	2,257,893.29
210205	Эрүүл мэндийн даатгал	23,792,200.00	22,578,433.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,843,700.00	59,021,305.00
210301	Гэрэл, цахилгаан	11,643,700.00	14,957,882.00
210302	Түлш, халаалт	38,200,000.00	34,211,940.00
210303	Цэвэр, бохир ус	12,000,000.00	9,851,483.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,970,800.00	13,969,156.00
210401	Бичиг хэрэг	1,320,900.00	1,320,900.00
210402	Тээвэр, шатахуун	684,700.00	684,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,013,100.00	5,012,426.00
210404	Ном, хэвлэл	860,500.00	882,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	607,900.00	591,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,483,700.00	5,476,380.00



2105	Нормативт зардал	2,215,700.00	2,215,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	202,600.00	125,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,013,100.00	2,090,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	810,500.00	810,500.00
210702	Дотоод албан томилолт	810,500.00	810,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	787,900.00	787,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	787,900.00	787,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13435600.00	13435600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,150,000.00	4,150,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,285,600.00	9,285,600.00
211	ХҮҮ	00.00	3,190,887.24
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	00.00	3,190,887.24
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	00.00	3,190,887.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73190900.00	73190900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,190,900.00	73,190,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	73,190,900.00	73,190,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,509,569,800.00	1,509,569,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,442,726,100.00	1,442,726,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,442,726,100.00	1,442,726,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	66,843,700.00	66,843,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	66,843,700.00	66,843,700.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00